



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 750,000 /долоон зуун тавин мянга/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 750,000 /долоон зуун тавин мянга/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэсэнтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.16-д заасан зөвшөөрлийг Монгол Улсын Сангийн яамнаас авсны үндсэн дээр худалдахыг “Монголын төмөр зам” ТӨХК /Р.Батсүх/-д мэдэгдсүгэй.

3. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК /Р.Батсүх/-д үүрэг болгосугай.

1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллах;

2/ Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг Хороонд улирал тутам ирүүлэх.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН